



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 1151

Улаанбаатар хот

### Судалгаа хийлгэх тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 19/24 дүгээр тогтоолоор батлагдсан “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн 2.4.5, Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай нийслэлийн Засаг даргын 2015 оны А/198 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.3, 3.2.3, 3.2.4, дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Улаанбаатар хотод аялсан гадаад жуулчдын сэтгэл ханамжийн судалгаа”-ны ажлыг гүйцэтгэх бага үнийн санал ирүүлсэн “Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төв” ТББ-тай гэрээ байгуулсугай.

2. Гэрээт ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, судалгааны тайланг 2015 оны 10 дугаар сарын 01-ний дотор хүлээн авч танилцуулахыг Статистик, судалгаа хариуцсан мэргэжилтэн /Б.Жаргалан/-д үүрэг болгосугай.

3. Судалгааны ажлын зардал болох 15.200.000 /арван таван сая хоёр зуун мянган/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Э.БАТТУЛГА